

Докторант Д.Бямбажав
МУБИС-ийн Нийгмийн Ухааны тэнхимийн багш
Докторант Ц.Мөнхцэцэг
МУБИС-ийн Нийгмийн Ухааны тэнхимийн багш

Ерөнхийлөгчийн засаглалаас татгалзахуй

Өгүүллийн товч утга: 1990 оноос эхлэн улс төрийн модернизаци хийгдэж байгаа улс орнуудын улс төрийн тогтолцоо, түүнд Ерөнхийлөгчийн засаглалыг сонгож авсан улс орнуудын (посткоммунист орнууд) засаглалын харилцаанд хийсэн улс төрийн анализ. Ардчилсан шилжилтэд Ерөнхийлөгчийн засаглалын (нэг хүний) үзүүлж буй сөрөг нөлөө, нэг хүний авторитари засаглал тогтож буй байдалд хийсэн дүн шинжилгээ.

Түлхүүр үг: ардчилсан шилжилт, улс төрийн модернизаци, ерөнхийлөгчийн институт, ардчиллын ухралт, авторитаризм

XX зууны хоёр дахь хагаст дэлхийн өнцөг булан бүрт дарангуйлагч дэглэмээс ардчилалд шилжих үйл явц өрнөж нийтдээ 100 гаруй улс хамрагдсан юм. Ардчилах үйл явц нь уналт, сэргэлтийг хосолсон үзэгдэл болох нь эдгээр улсуудын түүхээс харагдаж байна. Зарим улс орнууд дарангуйллаас ардчилал руу шилжиж байхад зарим нь ардчиллаас дарангуйлал руу ухарч буй байдал 20-р зууны түүхэнд олонтаа гарчээ. Цаашид ч ийм үйл явц өрнөхийг Зүүн Европ, Төв Ази, Латин Америк дахь улс төрийн дэглэмийн өөрчлөлт, шилжилт харуулж байна. 21-р зуунд дэлхий дахинаа ардчиллын байдал сайжрах эсэх, либерал ардчилсан улсуудын тоо нэмэгдэх эсэх, шинээр болон сэргэн тогтоогдсон ардчиллын цаашдын хөгжил ямар байх нь олон хүчин зүйлээс хамаарах нь дамжиггүй.

Ардчилал хөгжин төлөвшихэд олон хүчин зүйлс, нөхцөл нөлөөлдгийг судлаачид тодорхойлсон байдаг. Тухайлбал эдийн засаг, соёл, шашин, боловсрол зэрэг суурь нөхцөл чухал болохыг Р. Даль нарын судлаачид онцолсон байдаг. Харин эдгээр урьдач хүчин зүйлээс илүү улс төрийн системийн ямар хэлбэр, институт төлөвшиж тогтох нь ардчиллын цаашдын хувь заяанд шууд нөлөөлдөг гэдэгт мөн олон судлаач санал нэгтэй байдаг юм.

Тухайн улс өөрийн ардчилсан Үндсэн хуулийг боловсруулан батлахдаа улс төрийн ямар институтууд: ерөнхийлөгчийн ба парламентын засаглалын хэлбэр, сонгуулийн систем, төрийн холбооны болон нэгдмэл байгууламж, төвлөрсөн удирдлага ба эс төвлөрөл, хууль тогтоох байгууллагын бүтэц онцлог /нэг ба хоёр танхимт/, үндсэн хуулийн хяналтын байгууллагын хэлбэр ямар байх зэрэг маш чухал асуудлаар сонголт хийх шаардлагатай тулгардаг. Алийг нь сонгож хэрэгжүүлсэнээс ардчилах үйл явц, улс төрийн тогтолцооны үр ашиг олон талаар хамаарч буйг судлаачид илрүүлсэн нь бий. Эдгээрээс төрийн засаглалын хэлбэр болон сонгуулийн системийн сонголт нь либерал ардчилал төлөвшиж хөгжихэд амин чухал болохыг А. Липхарт, Ф. Ригс, Х. Линз нарын олон судлаачид онцолж байна.

Юуны өмнө төрийн засаглалын дээрх хоёр хэлбэрийн гол онцлог хийгээд үндсэн ялгааг гурван зүйлээр товчхон тайлбарлая. Нэгд, парламентын засаглалд засгийн газрын тэргүүн хийгээд түүний танхим нь хууль тогтоох байгууллагаас эх сурвалжтай, түүнээс хамааралтай байдаг. Хууль тогтоох байгууллага нь засгийн газарт итгэл үзүүлэх эсэх эрхтэй бөгөөд огцруулах боломж нээлттэй байдаг. Харин ерөнхийлөгчийн засаглалд засгийн газрын тэргүүн нь ерөнхийлөгч байх агаад Үндсэн хуулинд заагдсан тодорхой хугацаанд сонгогдож ажилладаг. Хууль тогтоох байгууллагын зүгээс ерөнхийлөгчийг огцруулах нь ихээхэн бэрхшээлтэй бөгөөд практикаас үзэхэд ерөнхийлөгч гэмт хэрэгт холбогдох зэрэг онцгой нөхцөлд л ийм боломж гардаг

байна. Хоёрт, Засгийн газрын тэргүүн болох ерөнхийлөгч нь ард түмнээс шууд сонгогддог бол ерөнхий сайд нь хууль тогтоох байгууллагаас сонгогдон томилогддог. Ерөнхий сайдыг сонгож томилох нь улс орнуудад өөр өөр хэлбэртэй байдаг. Тухайлбал: Германы канцлерыг Бундестагаас сонгодог, Японы ерөнхий сайдыг Төлөөлөгчидийн танхимаас, Өмнөд Африкийн "ерөнхийлөгчийг" Үндэсний ассамблей, Их Британид парламетанд олонхи болсон нам хүчний тэргүүнийг Хатан хаан Ерөнхий сайдаар дэвшүүлдэг. Гуравт, парламентын засаглалд гүйцэтгэх эрх мэдэл хамтын буюу танхимын зохион байгуулалтаар хэрэгждэг бол ерөнхийлөгчийн засаглалд энэ нь нэг хувь хүн буюу танхимын бус зарчмаар хэрэгждэг. /Lijphart, 7/ Танхимын зохион байгуулалтад ерөнхий сайдын байр суурь, үүрэг нь танхимын бусад гишүүд сайд нараас их бага хэмжээгээр хамаарч, гаргаж буй шийдвэр хамтын шинжийг илүүтэй агуулж байдаг. Харин ерөнхийлөгчийн институтын хувьд танхимын гишүүд нь зөвлөгч, туслагчийн үүрэгтэй байх нь илүүтэй ажиглагддаг. Тиймээс парламентын засаглалд засгийн газрын шийдвэр нь зөвхөн ерөнхий сайдын байр суурийг бус танхимыг бүхэлд нь төлөөлж байдаг бол ерөнхийлөгчийн засаглалд ерөнхийлөгч танхимын гишүүдийн зөвлөгөөг үл харгалзах буюу түүний эсрэг утга бүхий шийдвэр гаргах боломжтой байдаг.

Төрийн засаглалын дээрх хоёр хэлбэрийн үндсэн ялгаа бол хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хоорондын эрх мэдлийн хуваарилалт, харилцан хамаарал юм. Парламентын засаглалд гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох байгууллагын олонхиос шууд хамааралтай байх ба парламент дахь олонхийн дэмжлэг, байр сууриа хадгалж байх зайлшгүй шаардлагатай байдаг. Парламент дахь олонхийг бэхжүүлэхэд намын зохион байгуулалт, дэг журам, зөвшилцөл, хамтын ажиллагааг бүрдүүлэх хэрэгтэй болдог. Аль нэгэн нам олонхи болж чадаагүй бол олонхийг бий болгох, харилцан өөрсдийн эрх ашгийг хэрэгжүүлэх зорилгоор эвсэх шаардлага тулгардаг. Парламентын засаглал нь засгийн эрх мэдлийг тухайн нэгэн хувь хүнээс хамааралтай болгохоос хязгаарлаж улс төрийн нам хэмээх институттай илүүтэй холбож өгдөг.

Ерөнхийлөгчийн засаглалд хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдэл бие даасан шинжтэй байх ба ерөнхийлөгч нь ард түмнээс шууд сонгогдож байдаг. Тиймээс парламент дахь олонхиос төдийлөн хамааралгүй байдаг. Ерөнхийлөгч хэдийгээр улс аль нэгэн нам хүчнээс нэр дэвшдэг ч сонгогчид тухайн нэгэн намыг бус хувь хүнийг үндсэн хуулинд заасан тодорхой тогтоосон хугацаанд ажиллуулахаар сонгодог.

Парламентын болон ерөнхийлөгчийн засаглалыг хослуулсан холимог хувилбарууд мөн байдаг хэдий ч тэдгээрийг энэ хоёрын аль нэгд илүү ач холбогдол өгсөн буюу эрх мэдлийн хэмжээгээрээ нь ерөнхийдөө парламент ба ерөнхийлөгчийн хэлбэрийн аль нэгэнд багтаан үзэх боломжтой юм.

Засаглалын дээрх хоёр хэлбэрийн улс орнуудад тархсан байдал нь бүс нутгаараа ихээхэн ялгаатай. Баруун болон Зүүн Европын ихэнхи ардчилсан улсууд /Францыг үл оролцуулан/ парламентын засаглалтай. Түүнчлэн парламентын засаглал нь хуучин Британы эзэмшилд байсан улсуудад нийтлэг байдаг. Ерөнхийлөгчийн засаглал АНУ-аас анх эхлэлтэй бөгөөд Латин Америкт нэлээд ихэд дэлгэрсэн байхын сацуу Филиппин, Өмнөд Солонгос, мөн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудад байна. Ялангуяа 1980-1990-ээд онд Латин Америк болон Азийн шинээр ардчиллыг тогтоосон бүх улс орнууд, хуучин ЗХУ-ын нөлөөнд байсан 25 улсын дөрөвний гурав нь ерөнхийлөгчийн засаглалыг сонгож хэрэгжүүлжээ.

Монгол улс 1992 онд баталсан Үндсэн хуулиараа парламентын засаглалыг сонгон бүрдүүлсэн бөгөөд улмаар 2000 онд Үндсэн хуулинд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр засаглалын энэ хэлбэрийг улам бүр баталгаажуулсан юм. Гэхдээ сүүлийн үед төрийн тогтолцооны өнөөгийн энэ

хэлбэрийг өөрчлөх, ерөнхийлөгчийн засаглалыг дэмжих хандлага улс төрчид, сэтгүүлчид болон судлаачдын дунд ихээхэн яригдах боллоо. Мөн олон нийтийн санал асуулгын цуврал судалгаануудаас үзэхэд эв нэгдэлгүй улс төрийн олон нам хүчнүүд төрийн эрхэнд гарах болсон нь сөрөг үр дагавар авчирч байна гэж үзэн хүчтэй ерөнхийлөгчийн засаглалыг хүсэмжлэх болсон нь бас ажиглагдаж байна. Тийм учраас засаглалын хэлбэрийг өөрчлөх нь Монголын улс төрийн амьдралд хэрхэн тусах вэ, бодит хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юу гэдэг талаар онолын болон харьцуулсан судалгаа хийх шаардлага улс төрийн шинжлэх ухааны өмнө тулгарч байгаа юм. Бид энэ өгүүлэлд төрийн засаглалын хэлбэрийн асуудлыг хөндөж тавьсан бөгөөд ерөнхийлөгчийн ба парламентын институт нь ардчиллын хөгжил болон улс төрийн тогтолцооны үр ашигт хэрхэн нөлөөлдөгийг харьцуулан авч үзэхийг зорьлоо.

Дэлхийн улс орнуудын туршлага, ардчиллын түвшин, нэр хүнд бүхий судлаачдын дүгнэлтээс үзэхэд парламентын засаглалтай харьцуулахад ерөнхийлөгчийн засаглал нь сул тал ихтэй, улс орон бүрт тэр бүр дасан зохицох, үр дүнгээ өгөхдөө тааруу систем болох нь ажиглагдаж байна.

Ерөнхийлөгчийн засаглалд ямар ямар сул тал байдаг вэ? Ерөнхийлөгчийн ба парламентын системийг харьцуулсан судалгаа орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд онолын болон эмпирик түвшинд олонтаа хийгджээ. Эдгээрээс хамгийн үндэслэл сайтай, онолын суурь судалгааг Хуан Линз хийсэн байдаг. Линз /1990, 1994/ өөрийн бүтээлд төрийн засаглалын хоёр хэлбэрийг харьцуулж, ингэхдээ ерөнхийлөгчийн засаглалын сөрөг талуудыг илүү онцлон шүүмжилж, ардчиллын хөгжил төлөвшилд парламентын засаглал илүү ээлтэй болохыг хэд хэдэн үндэслэлээр нотлон харуулсан юм.

Түүний үзсэнээр /1994, 8-10/ ерөнхийлөгчийн засаглалын эхний сул тал бол уян хатан бус шинж юм. Парламентын тогтолцоонд улс төрийн нам сонгогдож засгийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг бол ерөнхийлөгчийн тогтолцоонд хувь хүнийг үндсэн хуульд тодорхой заасан хугацаанд ажиллуулахаар сонгодог. Тухайн ерөнхийлөгч ажлаа маш сайн хийж байсан ч ажиллах хугацааг цааш сунгах боломжгүй байдгийн адил хэрэв ерөнхийлөгч үүргээ гүйцэтгэж чадахгүй байсан ч парламент огцруулах боломж мөн байдаггүй юм. Зөвхөн тухайн ерөнхийлөгч маш хүндээр өвчилсөн буюу онц ноцтой гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд л огцруулж болно. Ийм тохиолдолд ерөнхийлөгч өөрөө огцорч болох ч улс орнуудын түүхэнд ийм явдал бараг гарч байсангүй. Мөн түүнийг импичментээр огцруулж болох ч энэ нь нэлээд хугацаа шаарддагаас гадна парламентын үнэмлэхүй олонхийн санал хэрэгтэй байдаг. Нэгэнт парламент хэдий ерөнхийлөгчид итгэл үзүүлэхгүй байгаа боловч түүнийг огцруулж чадахгүй байх нөхцөл үүсэх нь нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх аюултай байдаг. Өөрөөр хэлбэл ерөнхийлөгчийн засаглал нь "дархлаа" ихтэй тогтолцоо бөгөөд нэгэнт сонгогдсон бол ямар ч явуургүй үйл ажиллагаа явуулж байсан ч огцруулах аргагүй институт болж хувирдаг байна.

Гэтэл парламентын засаглалд ийм асуудал үүсдэггүй бөгөөд засгийн газрын тэргүүнд парламентын олонхи итгэл үзүүлэх эсэхээ богино хугацаанд шийдэх боломжтой байдаг. Нэгэнт итгэл үзүүлээгүй тохиолдолд засгийн газар огцрох ба нийгэм улс төр эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэлгүйгээр дараагийн шинэ засгийн газар байгуулагддаг. Засгийн газрын тэргүүн болон гишүүд гэсэн хувь хүмүүсийг сольсноор эрх баригч нам өөрийн бодлого, хөтөлбөрөө цаашид тасралтгүй үргэлжлүүлэх боломжтой байдаг. Тиймээс энэ нь ерөнхийлөгчийн засаглалд илэрдэггүй илүү уян хатан шинжийг бий болгож байдаг байна.

Линзийн дэвшүүлсэн хоёр дахь үндэслэлээр ерөнхийлөгчийн тогтолцоо нь "хоёр толгойт" засаглалыг бий болгодог. Парламентын засаглалд хууль

тогтоох байгууллагын гишүүд л ард түмнээс шууд сонгогдож тэдний төлөөлөл болдог бол ерөнхийлөгчийн засаглалд ерөнхийлөгч болон парламент хоёул ард түмнээс шууд сонгогддог тул аль аль нь ард түмний хууль ёсны төлөөлөл болдог. Үүнээс хамааран эдгээрийн хооронд улс төрийн зөрчилдөөн, үл ойголцол үүсч, төрийн механизм “гацаанд орох” магадлал их байдаг.

Хэдийгээр анх АНУ-д гүйцэтгэх засаглалд тавих хяналтыг бий болгох үүднээс ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллагын эрх мэдлийг нарийн зааглан хуваарилсан боловч энэ нь бодит байдал дээр ерөнхийлөгчид илүү эрх мэдлийг бий болгож эргээд түүний сонгогдох хугацааг богиносгох зэргээр эрх мэдлийг нь хязгаарлах болжээ. Гэтэл ингэснээр эргээд улс төрийн сөрөг үр дагаварт хүргэдэг байна. Юуны өмнө энэ сонгогч өөрийн хамгийн ихээр дэмжиж буй нэр дэвшигчээ сонгох ёстой ардчилсан зарчмыг зөрчдөг. /Lijphart, 8/ Нөгөө талаас нэгэнт цаашид үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болж байгаа ерөнхийлөгчийн хувьд оюуны болоод биеийн хүчин зүтгэл нь буурах, “хоногоо хүлээх”-д түлхэдэг. Гэтэл парламентын тогтолцоонд ийм “гацаа” болон хэн нэгэн ерөнхий сайдын ажиллах хугацаанд цаг хугацааны хязгаар тавих явдал байдаггүй.

Линзийн дэвшүүлсэн 3 дахь үндэслэл нь ерөнхийлөгчийн засаглалд “ялагч бүгдийг авна” хэмээх зарчим үйлчилдэг буюу сонгуульд ялагч нь гүйцэтгэх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлдэг явдал юм. /1994, 10/ Гэтэл сонгуульд ялагдсан нэр дэвшигчийн хувьд “ялагдвал бүгдийг алдах” зарчим үйлчлэх ба түүний хувьд улс төрийн тавцанаас аажмаар холдох нь нийтлэг байдаг.

Линзийн эдгээр үндэслэлүүдээс гадна дэлхийн улсуудын практикаас харахад ерөнхийлөгчийн засаглалын сул талууд олон зүйл дээр илэрч байна.

Ерөнхийлөгчийн засаглалын үед сонгуульд ялсан тал дараагийн сонгууль хүртэл дангаар ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломжтой болж гүйцэтгэх засаглалд дан ганц нэг хүчний манлайлал хүчтэй болдог юм. Хэрэв парламентын сонгуульд ерөнхийлөгчийн нам мөн олонхийн суудал авсан байвал улс төрд нэг намын онцгой нөлөө, олигархи үүсдэг нь өнөөгийн ОХУ-ын жишээн дээрээс харагдаж байна. Хэдийгээр олонхи, дийлэнхийн сонгуулийн систем бүхий парламентын тогтолцоснд мөн “ялагч бүгдийг авах” зарчим үйлчилдэг боловч энэ тохиолдолд ялагч нь нэг хувь хүн биш харин нам байдаг. Ялагдагчийн хувьд энэ нь мөн л нам байх агаад улс төрийн тавцанд сөрөг хүчний үүрэг гүйцэтгэсээр байдаг. Үндэстэн угсаатан, шашны гүнзгий ялгарал бүхий нийгмийн хувьд дээрх зарчимд үндэслэн ерөнхийлөгчийн засаглал нь маш аюултай байдаг. Учир нь ерөнхийлөгч өөрөө аль нэгэн угсаатан, шашины төлөөлөгч байх агаад үүнээс үүдэлтэй нийгмийн бусад хэсгийг ялгаварлах хандлага бий болдог байна. Гэтэл танхимын зохион байгуулалт бүхий парламентын засаглал нь нийгмийн олон янзын бүлэг давхрааны төлөөлөл чадвар өндөртэй байдаг.

Ерөнхийлөгчийн засаглалын бас нэгэн сөрөг үр дагавар бол улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлж, хувь хүний үүрэг ролийг улс төрийн амьдралд чухал болгон кувиргадаг явдал юм. /Linz, 1990/ Ерөнхийлөгчийн тогтолцоонд улс орны амьдралд онцгой эрхтэй ерөнхийлөгч болох хувь хүний хүчин зүйл онцгой нөлөөтэй байдаг. Ялангуяа улс төрийн нам, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн үндсэн институтуудын төлөвшилт сул байгаа нөхцөлд дээрх ерөнхийлөгчийн хувийн үүрэг роль нийгэмд хүчтэй болдог. Харин АНУ зэрэг либераль ардчиллын уламжлалтай оронд улс төрийн тогтолцоо нь хувь хүнээс, тухайлбал, ерөнхийлөгч хэн болох, парламентын спикер хэн болохоос үл хамаардаг, бүх талын хяналт хүчтэй байдаг тул ерөнхийлөгчийн засаглалын энэхүү сул тал төдийлөн гардаггүй байна. Гэтэл шилжилтийн орнууд болон ардчиллын уламжлалгүй орнуудад ерөнхийлөгчийн хувийн шинж

төрх, улс төрийн хүсэл эрмэлзэл, удирдлагын арга барилаас ардчиллын ирээдүй, улс төрийн тогтолцоо хамаарах болдог. Тухайлбал, 70-аад онд Африкийн Малави улсад ерөнхийлөгч нь үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулах эрхээ ашиглан бүх насаараа энэ албыг хаших болсон гашуун түүх бий. Улс төрийн хариуцлага бүхийн мөрийн хөтөлбөр, бодлогод суурилахын оронд шууд олон нийт, хүлээлтэнд тулгуурлаж гарч ирдэг популист дэглэмүүд гол төлөв ерөнхийлөгчийн засаглалтай улсуудад тогтож ирсэн юм.

Ерөнхийлөгчийн тогтолцоонд гүйцэтгэх засаглал нь парламент болон намуудын хүчний харилцаанаас үл хамаардаг учраас улс төрийн намын төлөвшилт сул, ихэвчлэн үзэл баримтлалаараа маш ойролцоо, харьцангуй сул зохион байгуулалттай намуудын систем үүсдэг байна. Гэтэл судлаачдын үзэж буйгаар улс төрийн нам бол ардчиллын нэн чухал институт байх ёстой бөгөөд төлөвшиж тогтсон намгүйгээр орчин үеийн ардчиллыг төсөөлөх боломжгүй болжээ.

Засаглалын үр ашигт төлөвшиж тогтсон намын систем ихээхэн нөлөөлдөг. Харин шилжилтийн үедээ явж буй улс орнуудад намын систем тэр болгон бүрэлдэн бий болоогүй байдаг. Ж.Сартори улс төрийн намууд нь тоглоомын шударга дүрмээр өрсөлддөг, улс төрийн хариуцлага хүлээхүйц чадвартай, зохион байгуулалт, сахилга баттай болон нийгэмшиж байж парламентад дүйцэх намууд болдог. Ийм намгүйгээр ардчилал хэрэгжих боломжгүй хэмээн үзсэн байдаг. /Hipsheer, 1997 дам ишлэв/

Зарим судлаачид танхимын зарчмаар ажилладаг парламентын тогтолцоонд тодорхой нэгэн хошуучлагч, хүчний төв болоод хариуцлага хүлээх эзэн байдаггүйг шүүмжилсэн байдаг. /Mainwaring and Shugart/ Тэд Латин Америкийн улс орнуудыг судлаад дээрх улсуудад парламентад олонхи болохын тулд намуудын хамтран байгуулсан эвсэлийн сул талууд болон хүчтэй удирдлага эрх мэдлийн төвлөрөл үгүй байдал нь ерөнхийлөгчийн тогтолцоог сонгоход нөлөөлжээ хэмээн дүгнэсэн байна. Түүнчлэн нийгэм дэх ядуурал, эмх замбараагүй байдал, авилгал, хүнд сурталыг үгүй хийхэд хүчтэй ерөнхийлөгч хэрэгтэй гэсэн нийгмийн сэтгэл зүй үүнд нөлөөлдөг байна. Ийм сэтгэл зүй нь өөрөө нийгмийн бухимдал, мухардмал байдлаас үүдэлтэй "хатуу гарын домгийг" бий болгодог хэдий ч хатуу гартай ерөнхийлөгч дээрх нийгмийн асуудлуудыг шийдэж чадсан амжилт харамсалтай нь маш ховор байна. Эрх мэдлийн төвлөрөлд түшиглэн шийдвэрийг богино хугацаанд гаргаж бодлого хэрэгжүүлэх нь чухал гэдэг санаа нь төдийлөн оновчтой биш юм. Учир нь асуудлыг нэг талаас нь харсан ийм шийдвэр үргэлж үр дүнтэй байдаггүй. Судлаачдын олж илрүүлснээр харилцан зөвшилцсөн, олон талт хувилбарыг хэлэлцэж байж шийдээр гагах нь илүү үр өгөөжтэй байж иржээ.

1990-ээд оноос хойш посткоммунист орнуудын ардчилалд шилжих үйл явц өрнөсөнтэй холбогдуулан ерөнхийлөгчийн ба парламентын засаглалын талаархи харьцуулсан судалгаанууд нилээд олноор хийгдсэн бөгөөд ихэнхи нь Линзийн дэвшүүлсэн үндэслэлийг дэмжсэн дүгнэлтүүд гаргажээ.

Пауэр болон Гашировски нар /Power & Gasiorowski/ хөгжиж буй 56 улсыг судлан үзээд засаглалын хоёр хэлбэр улс төрийн дэглэмд шууд нөлөөлдөггүй боловч улс төрийн үйл явц, шийдвэр, эдийн засгийн хөгжилд олон талаар нөлөөлж иржээ гэсэн дүгнэлт хийсэн байна. Засгийн газрын бүтэц хэлбэр ялангуяа шинэ ардчилсан улсуудад, тэдний төрийн бодлого, иргэний эрх чөлөө, эдийн засаг, ерөнхий ардчиллын түвшинд чухал нөлөөтэй болохыг онцолжээ. Судлаач Пщеворски 1950-1990 оны хоорондох 135 улсын статистик тоо баримтад дүн шинжилгээ хийсэн судалгаандаа үндэслэж "парламентын тогтолцоо нь ерөнхийлөгчийн тогтолцооноос хавьгүй удаан хугацаанд оршин тогтнодог..." хэмээн / Hipsheer, 1997 дам ишлэв / дүгнэжээ. Өөрөөр хэлбэл

парламентын засаглал нь ардчилсан тогтолцоо болохын хувьд илүү "дархлаа" сайтай, оршин тогтнох илүү чадвартай гэсэн үг юм.

Арендт Липхарт 1977-1996 хүртэл буюу 20 орчим жил ардчилал тогтвортой байсан улсуудыг тогтвортой либерал ардчилсан улсууд гэж тодорхойлсон /Lijphart 1999/ агаад үүндээ нийт 36 улсыг багтаан оруулжээ. Дэлхийн улсуудын засаглалын хэлбэрийг парламентын ба ерөнхийлөгчийн хэмээн хоёр хэсэгт хуваан үзвэл хоорондын тоон харьцаа нь 3:2 буюу маш бага ялгаа байна. Гэтэл Липхартын судалгаагаар дээрх 36 улсын 5 нь л ерөнхийлөгчийн засаглалтай ажээ. Цаашлаад 2000 он хүртэл үргэлжлүүлэн авч үзвэл дээрх 36 либерал ардчилсан улсын тоо 34 болон цөөрч үүнээс ерөнхийлөгчийн засаглалтай Венесуэл, Колумби улсууд энэ тооноос хасагдаж одоо ердөө АНУ, Коста Рика, Франц гурав л үлджээ. Тиймээс либерал ардчилсан улсуудын зөвхөн 10 хүрэхгүй хувь нь л ерөнхийлөгчийн засаглалтай улс байна гэж дүгнэж болох нь. / Lijphart 2000, 11/

1970-аад оноос эхэлсэн ардчиллын "гурав дахь давалгааны" эхэнд Өмнөд Европын авторитар дэглэмтэй байсан Грек, Испани, Португали зэрэг улсууд ерөнхийлөгчийн засаглалаа парламентынх болгосны үр дүнд ардчилалд амжилттай шилжиж, өдгөө либераль ардчилсан улсуудын нэг болсон юм. Испанид тогтож байсан Франкогийн диктатураас үлдсэн ул мөр, улс төрийн зөрчил мөргөлдөөнийг арилгахад парламентын систем онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Харин Латин Америкийн улсууд ерөнхийлөгчийн уламжлалт засаглалдаа үнэнчээр үлдсэн нь ардчиллын хөгжилд тэр бүр зэрэгээр нөлөөлөөгүй юм. Иргэний нийгмийн зүгээс эрх баригчдын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл сул, хүчний байгууллагуудыг ерөнхийлөгч өөрийн дур зоргоор удирдан чиглүүлж байсан зэрэг нь эдгээр улсууд дахь ардчилалд сөрөг нөлөө үзүүлсэн юм. Мөн эдгээр оронд сонгогчдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх аргаар удаа дараа популистууд төрийн эрхэнд гарч байсан байна. Өнөөдөр Латин Америкийн улсуудын нэлээд нь хагас ардчилсан дэглэмтэй хэвээр байгаа юм. Тиймээс "Гуравдагч ертөнц"-ийн орнууд дахь ерөнхийлөгчийн засаглал нь авторитар дэглэмийг нуух баг болдог гэж зарим судлаачид үздэг байна.

Ерөнхийлөгчийн болон парламентын засаглал посткоммунист улс орнуудад ардчиллын түвшний хувьд ялгаатай үр дагаврыг бий болгожээ. АНУ-ын Фридом Хаус байгууллагын 2005 оны Дэлхий дахины эрх чөлөөний байдал судалгаанд дэлхийн улсуудыг эрх чөлөөт, хагас эрх чөлөөт болон эрх чөлөөт бус гэж ангилан үзсэн байх агаад посткоммунист гэгддэг 28 улсууд дараахи байдалтай байна. /Хүснэгт 1./

Эрх чөлөөт	Хагас эрх чөлөөт	Эрх чөлөөгүй
Чех	Албани	Азербайжан
Эстони	Македони	Казакстан
Унгар	Босни-Херцеговин	Белорусь
Литва	Гүрж	Кыргизстан
Польш	Молдав	ОХУ
Словени	Украин	Тажикстан
Словак	Армени	Узбекистан
Латви		Туркменистан
Болгар		
Монгол		
Румын		
Серби-Черногори		
Хорват		

Хүснэгтээс үзэхэд дээрх улсуудын 15 нь буюу 53 хувь нь хагас эрх чөлөөт болон эрх чөлөөт бус хэмээн тооцогджээ. Ялангуяа тэдгээрийн 8 нь эрх чөлөөгүй буюу авторитар улс гэж тооцогдох болж ардчиллаас хол ухарчээ. Ардчиллаас ухрах хийгээд ардчиллаас авторитар дэглэм рүү хийх шилжилтийн шалтгааныг судлаачид эдийн засгийн хөгжил, тухайн улсын хэмжээ, соёл, дайн дажин, харийн түрэмгийлэл, үзэл суртлын ялгарал, сонгуулийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж ирсэн хэдий ч посткоммунист улсуудад ажиглагдаж буй ухралтын үндсэн шалтгаан нь ерөнхийлөгчийн засаглал, түүний эрх мэдлийн хэтийдэл болжээ. /Fish, 2001/

Бид посткоммунист улсуудын төрийн засаглалын хэлбэрийг харьцуулан үзлээ /Хүснэгт 2./

Улсууд	Дэглэмийн шинж	Төрийн засаглалын хэлбэр	Ерөнхийлөгч
Чех	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Вацлев Клаус /2003-өнөөг хүртэл/
Хорват	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Степан Месич /2000-өнөөг хүртэл/
Эстони	Эрх чөлөөт	Парламентийн	
Унгар	Эрх чөлөөт	Парламентийн	
Латви	Эрх чөлөөт	Парламентийн	
Литва	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Валдав Адамкус /2004-өнөөг хүртэл
Польш	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн /холимог/	Александр Квасневски /1995-өнөөг хүртэл/
Словени	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Янец Дрновсек /2002-өнөөг хүртэл/
Словак	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Иван Гаспарович /2004-өнөөг хүртэл/
Болгар	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн	Георги Пурванов /2002-өнөөг хүртэл/
Монгол	Эрх чөлөөт	Парламентийн	
Румын	Эрх чөлөөт	Ерөнхийлөгчийн /холимог/	Траян Басеску /2004-өнөөг хүртэл/
Серби	Эрх чөлөөт	Парламент	
Албани	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Альфрэд Мойзин /2002-өнөөг хүртэл/
Македони	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Бранко Крвенковски /2004-өнөөг хүртэл/
Босни-Херцеговин	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Борислав Паравач /2004-өнөөг хүртэл/
Гүрж	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Михаел Сакашвили /2004-өнөөг хүртэл/ Эдуард Щеварднадзе /1995-2004/
Молдав	Хагас чөлөөт эрх	Парламентийн /холимог/	
Украин	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Виктор Ющенко /2005-өнөөг хүртэл/ Леонид Кучма /1994-2005/
Армени	Хагас чөлөөт эрх	Ерөнхийлөгчийн	Роберт Кочариан /1998-өнөөг хүртэл/
Таджикистан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Эмомали Рахманов /1994-өнөөг хүртэл/
Туркменистан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Сапармарат Неязов /1990-өнөөг хүртэл/
Азербайджан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Илхам Алиев /2003-өнөөг хүртэл/
Казакстан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Нурсултан Назарбаев /1991-өнөөг хүртэл/
Кыргизстан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Аскар Акаев /1990-өнөөг хүртэл/

Белорусь	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Александр Лукашенко /1994-өнөөг хүртэл/
ОХУ	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Владимир Путин /1999-өнөөг хүртэл/ Борис Ельцин /1991-1999/
Узбекистан	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгчийн	Ислам Каримов /1990-өнөөг хүртэл/

Улс орнуудын талаархи мэдээллийн эх сурвалж: CIA World Factbook 2004

Үндсэндээ дээрх улсуудын 80 гаруй хувь нь ерөнхийлөгчийн засаглалтай байгаа атал яагаад ардчилал, эрх чөлөө, дэглэмийн шинжийн хувьд ийм ялгаатай байдал үүсэв гэдэг нь анхаарал татаж байна. Хагас эрх чөлөөт болон ялангуяа эрх чөлөөгүй гэгдэгч улсуудын улс төрийн тогтолцоонд дараахи нийтлэг шинжүүд ажиглагдаж буйг судлаач С.Фиш онцолжээ./ Fish, 2001/ Үүнд ерөнхийлөгч нь улс үндэсний тусгаар тогтнол, үндэсний дэвшлийн удирдагч, баатарлаг дүр болон тодорсон бие хүмүүс байх агаад тэдгээрийн олонхи нь хуучин ЗХУ-ыг задарсанаас хойш цаг хугацааны хязгааргүйгээр улс орноо удирдаж иржээ. Тэд ихэнхдээ ард нийтийн санал асуулга явуулж олонхийн дэмжлэгийг аван өөрийн легитим шинжийг тогтоож байжээ. Зарим улсын тухайд ард нийтийн санал асуулгыг ерөнхийлөгчийн институтын зүгээс будлиантуулах, улс төрийн луйвар хийх аргаар ч зохион байгуулж байжээ. Энэ нь Украин, Белоруст болж өнгөрсөн саяхны үйл явдлуудаас харагдаж байгаа юм.

“Суперпрезидентизм” буюу ерөнхийлөгчид хэт их эрх мэдэл олгосон явдал эдгээр улсуудад нийтлэг байна. Төрийн бусад институтаас эрх мэдлийн хэмжээ, нөөцийн хувьд маш давуу ерөнхийлөгчийн институт, захирамж нь хуулийн адил үйлчлэлтэй, төсвийг зарцуулах эрх үндсэндээ ерөнхийлөгчид төвлөрсөн, хууль тогтоох байгууллага нь ерөнхийлөгчийн шийдвэрт хориг тавих боломж маш бага, ерөнхийлөгчийн импичментийн асуудлыг хөндөхөд саад бэрхшээл ихтэй буюу ерөөсөө боломжгүй, шүүх эрх мэдэл ерөнхийлөгчөөс бүрэн хараат байдалтай тул түүний үйл ажиллагаанд хяналт тавих чадваргүй болсон байна.

Судлаачдын ангиллаар хагас ардчилал болон авторитар дэглэм гэж тооцогдож буй посткоммунист зарим улсуудад ерөнхийлөгчийн засаглалын дараах шинжүүд ажиглагдаж байна. Албанийн парламентын систем нь ерөнхийлөгчид маш их эрх мэдлийг олгосон байх жишээтэй. Ерөнхийлөгч Бериша эрх мэдлээ ашиглан Үндсэн хуульд өөрчлөлт оруулж эрх мэдлээ нэмэгдүүлсэн байна. Армэнд мөн адил үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгч ихээхэн эрх мэдэл бүхий байж ирсэн. Белорусийн хувьд тусгаар улс болсны дараагаар хуучин дээд зөвлөлд гол эрх мэдэл хадгалагдаж байсан боловч 1994 онд парламентын засаглалыг ард нийтээс шууд сонгогддог ерөнхийлөгчийн засаглалаар сольсон. Хорватын Үндсэн хууль нь анх хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хоорондын эрх мэдлийн хуваарилалтыг харьцангуй тодорхой гаргаж өгсөн боловч ерөнхийлөгч Тужман дайнаас үүдэлтэй өөрт нь оногдсон үүрэгт дулдуйдан үндсэн хуульд өөрчлөлт оруулан, хууль тогтоох байгууллагын эрх мэдлийг хумиж, гүйцэтгэх эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн байна. Казакстан болон Киргизстаны хувьд тусгаар тогтносон эхний жилүүдээс л ерөнхийлөгчийн хүчтэй засаглалыг бий болгосон түүхтэй. Оросын хувьд эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэрийг хэдий хоёрдмол утгатай боловч Үндсэн хуульдаа тусгасан. Гэхдээ хууль тогтоох байгууллага дээд эрх мэдэлтэй боловч бодит байдалд ерөнхийлөгчийн шийдвэрт парламент хориг тавьж чаддаггүй байна. Цаашлаад ОХУ ерөнхийлөгчид хүчтэй эрх мэдлийг олгосон шинэ Үндсэн хуулиа батласан. Украины хувьд 1996 оныг хүртэл Үндсэн хуулиа батлаагүй байсан бөгөөд хуулийг батлахаас өмнө болон хойно ч адил ерөнхийлөгч маш их эрх мэдэлтэй байж ирсэн юм.

Эдгээр улсуудад Үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгчид эрх мэдлийн төвлөрлийг бий болгосон явдал нь тусгаар тогтнох хөдөлгөөн, хувьсгалыг удирдан манлайлсан хүмүүсийн харизм болон тухайн үеийн улс төрийн элитийн дэмжлэг, мөн олон нийтийн хандлагатай холбоотой юм. Хуучин дэглэмийн бурангуй байдлыг халан устгаж ардчиллыг цогцлуулан хөгжүүлэх эрмэлзлэлээр ийм системийг сонгосон нь дамжиггүй. Зарим улсад тухайлбал, Беларусьт бүх нийтийн санал асуулгаар дийлэнх иргэд хүчтэй ерөнхийлөгчийн төлөө санал өгсөн байх бөгөөд энэ нь номенклатур элитийн эрх мэдлийг хязгаарлаж, авилгыг багасгана гэдэг итгэлд хөтлөгдөж байжээ. Харин Үндсэн хуулиар олгосон эрх мэдлийн төвлөрөл нь эргээд ардчилалд сөрөг үр дагавар бий болгосон нь харамсалтай. Энэ төвлөрөлд дээрх улсууд дахь сөрөг хүчний нэгдмэл бус, сул дорой байдал таатай боломжийг бүрдүүлж, мөн геополитикийн гадаад хүчин зүйлс нэрмээс болсон гэж үзэж болно.

Засгийн эрхэнд гарсан ерөнхийлөгч нар сөрөг хүчнийг хяхан хавчих, тэр ч байтугай хүч хэрэглэн дарах явдал гарч байсан бөгөөд олон нийтийн дунд ч төрийн эрх баригчийн явуургүй үйл ажиллагаанд дургүйцэх хандлага хуримтлагдсаар байсан нь эцэстээ оршин буй дэглэмийг эсэргүүцсэн бүх нийтийн бослогод хүргэдэг нь 2003 оны Гүрж, 2004 оны Украин болон өнгөрсөн гурван сард Киргизэд болсон үйл явдлаас харагдаж байна. Киргизээс ялгаатай нь Гүрж, Украинд эрх баригчид нь сөрөг хүчний жагсаал, шаардлагын үр дүнд тайван замаар албан тушаалаа шилжүүлэн өгсөн юм. Харин Киргизийн Ерөнхийлөгч А. Акаевыг бослогын үр дүнд албан тушаалаас нь зайлуулжээ. Акаев 15 жил засгийн эрх барихдаа удаа дараа бүрэн эрхээ нэмэгдүүлсэн хууль, тогтоомж баталж байв. Тухайлбал, 1996 онд бүх нийтийн санал асуулгаар парламенттай зөвшилцөхгүйгээр засгийн газрыг томилох болон огцруулах эрх олж авсны зэрэгцээ үүрэгт ажлаа хүлээлгэн өгсний дараа ч гэсэн бүх насаараа төрийн үйл хэрэгт оролцоор байх онцгой эрхтэй болсон юм. Мөн 2001 онд парламентыг тараах бүрэн эрхийг өөрт олгосон хуулийг батлуулж чадсан юм. Акаев төрийн дээд албыг өөрийн хамаатан садан, ойр дотныхноороо бүрдүүлж байсан нь Казакстаны нөхцөл байдалтай адил юм. Киргизэд гурван сарын 13-д явагдсан парламентын сонгуульд нийт 75 суудлын 69-ийг нь эрх баригч нам авсны дотор Акаевын хүү, охин гэх мэт хамаатан садны 10 хүн сонгогдсон байжээ.

Гүрж, Украин, Киргизэд болж өнгөрсөн авторитар дэглэм, ганц хүний засаглалыг эсэргүүцсэн хөдөлгөөнүүдийн амжилт нь Төв Европ болон Төв Азийн бусад улс орнуудын сөрөг хүчинд сэдэл өгч улмаар цаашид ч ийм үйл явц удаа дараа өрнөж болзошгүй гэсэн таамаглал төрүүлж байгаа юм.

Монгол улсын хувьд ерөнхийлөгч болон парламентын аль алинийг ард түмнээс шууд сонгодог, хэлбэрийн хувьд холимог засаглалтай мэт боловч ерөнхийлөгчийн сонгуульд олонхийн санал авсан нэр дэвшигчийн бүрэн эрхийг УИХ хүлээн зөвшөөрсөн тогтоол гаргадгаараа үндсэндээ хууль тогтоох байгууллагаас хамааралтайгаар сонгогддог ерөнхийлөгч бүхий парламентын системтэй улс юм. Ерөнхийлөгчийн институтын эрх мэдлийн талаар манай судлаачдын дунд өөр өөр байр суурь бий. Үндсэн хуулиар олгосон эрх мэдэл нь их явцуу, парламент хэт давуу эрхтэй гэсэн ойлголт түгээмэл байдаг. Гэвч бодит улс төрийн практикт Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь парламентын засаглалтай улс орнуудын ерөнхийлөгчийн нэгэн адил хянан тэнцвэржүүлэгч шинжтэй гэж үзэж болох юм. Тухайлбал Үндсэн хуулийн өнгөрсөн 13 жилийн туршлагаас харахад ерөнхийлөгч ба Үндсэн хуулийн цэцийн хамтын хүч нь парламентын үйл ажиллагаа, гаргасан хуулиудад хяналтын үүрэг гүйцэтгэж ирсэн байна. Монгол улсын ерөнхийлөгчийн бусад улсуудын ерөнхийлөгчийн эрх зүйн байдлаас ялгагдах нэг онцлог бол хэдийгээр улс төрийн аль нэг намаас

сонгогддог боловч албан тушаалдаа орсон хойноо намаасаа татгалздаг явдал юм. Ингэснээрээ улс төрийн өөр өөр ацлиг сонирхол, улс төрийн тэмцлийн дүнд боловсруулсан хууль, бодлогод хараат бус, төвийг сахисан байр сууриар асуудалд хандах боломжийг өгдөг байна.

2000 онд Үндсэн хуулинд оруулсан өөрчлөлтийн зарим заалт нь ерөнхийлөгчийн эрх мэдлийг хөндөж парламентын засаглалын хэлбэр рүү илүү ойртуулсан юм. Тухайлбал, Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт оруулсан Ерөнхий сайдыг томилж чадахгүй бол УИХ өөрөө тарах, эсвэл Ерөнхийлөгч УИХ-ыг тараах гэсэн заалт нь ерөнхийлөгчийн бодит эрх мэдлийг нэмэгдүүлсний зэрэгцээ парламентын засаглал бүхий орнуудын түгээмэл жишгийг баримталсан өөрчлөлт юм.

Харин Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийн дагуу УИХ-д суудал авсан нам, эсвэл зөвшилцөж олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногт УИХ-д оруулах болсон нь бодит эрх мэдлийг хязгаарласан шинжтэй хэдий ч энэ мөн л парламентын засаглалтай орнуудын жишиг юм. Харин энэхүү өөрчлөлтийг Ерөнхийлөгчид зөвшилцөх боломж өгөхгүйгээр Ерөнхий сайдад нэр дэвшигч хэн нэгнийг тулган хүлээлгэж байна гэсэн шүүмжлэл байгаа хэдий ч хэрэг дээрээ бол парламентын сонгуульд ялсан намын тэргүүн ямар нэг саад бэрхшээлгүйгээр гүйцэтгэх засаглалын тэргүүн болдог байна. Төрийн тэргүүн болох хаан юмуу ерөнхийлөгч нь уг нэр дэвшигчийг буцаадаггүй, парламентад танилцуулахаар оруулдаг нь түгээмэл байна.

Эндээс үзэхэд Монголын өнөөгийн парламентын тогтолцоо болон энэхүү тогтолцоон дахь ерөнхийлөгчийн эрх мэдэл, статус нь дэлхийн улсуудын ерөнхий жишгийн дагуу бүрэлдсэн өөрчлөх шаардлагагүй байгаа юм. Дэлхийн улс орнууд, ялангуяа дарангуйлагч дэглэмээс ардчилалд шилжиж байгаа улсуудын практик болон онолын судалгаануудаас үзэхэд Ерөнхийлөгчийн засаглалыг сонгож авах шаардлагагүй, засаглалын энэ хэлбэр нь Монголын улс төрийн амьдралд ихээхэн сөрөг үр дагавартай гэж дүгнэж болохоор байгаа юм.

Ашигласан материал

Азийн сан. 2005. Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал сэдэвт бага хурлын материалын эмхэтгэл. УБ

Central Intelligence Agency. 2004. CIA World Factbook. at

<http://www.cia.gov/cia/publications/factbook/countrylisting.html>

Даль Р. 2004. Ардчиллын тухай. УБ:Адмон

Hipsher, Patricia L. "The Failure of Presidential Democracy." *Journal of Interamerican Studies and World Affairs*: Summer 1997

Lijphart, Arend. 1999. *Patterns of Democracy: Government Forms and Performance in Thirty-Six Countries*. New Haven: Yale University Press.

Lijphart, Arend. 2000. *Democracy in the Twenty-First Century: Can We Be Optimistic?*. The Eighteenth Uhlenbeck Lecture. Wassenaar: NIAS

Linz, J. 1994. "Presidential or Parliamentary Democracy: Does It Make a Difference?" In Juan J. Linz and Arturo Valenzuela, eds., *The Failure of Presidential Democracy*, pp. 3-87. Baltimore: Johns Hopkins University Press.

Linz, J. 1990. "The Perils of Presidentialism." *Journal of Democracy* 1(1): 51-69

Lawrence, Chris. Jennifer Hayes. 2000. *Regime Stability and Presidential Government A Preliminary Analysis*. Presented at the 72nd Annual Meeting of the Southern Political Science Association Atlanta, Georgia, 8-11 November 2000

Power, Timothy J., and Mark J. Gasiorowski. 1997. "Institutional Design and Democratic Consolidation in the Third World." *Comparative Political Studies*

- ,Vol.30,No.2 (April),pp.123-55.
- Riggs, Fred W. "Presidentialism vs. Parliamentarism: Implications for Representativeness and Legitimacy," *International Political Science Review*. 18:3 (1998) pp.253-278.
- Stepan,Alfred,and Cindy Skach.1994."Presidentialism and Parliamentarism in Comparative Perspective." In Juan J.Linz and Arturo Valenzuela,eds.,*The Failure of Presidential Democracy* ,pp.119-36.Baltimore:Johns Hopkins University Press.
- Samuels, David. Kent Eaton. 2002. *Presidentialism And, Or, and Versus Parliamentarism:The State of the Literature and an Agenda for Future Research.*